

ХАСБАНК ХК (“ХАСБАНК” ЭСХҮЛ “БАНК”)-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН МЯГМАР ГАРАГИЙН 09:00-11:30 (УЛААНБААТАРЫН ЦАГААР) ЦАГИЙН ХООРОНД МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ИХ ТАНХИМД ХУРАЛДСАН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ОГНОО БА ХУРАЛДСАН ГАЗАР

Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”) 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Мягмар гарагийн 09.00-11:30 цагийн /Улаанбаатарын цагаар/ хооронд Монгол Улс, Улаанбаатар хот, Шангри-Ла зочид буудлын Их танхимд хуралдав. Хурал танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдав.

ХЭЭХ-ыг монгол хэлээр хөтлөн явуулж, илтгэлүүдийг мөн монгол хэлээр тавьсан бөгөөд хурлын дарга Санжай Гүптагийн англи хэл дээр илтгэсэн нээлтийн үг болон бусад яриаг орчуулагчийн тусламжтайгаар монгол хэл дээр шууд хөрвүүлэн хүргэв. Гадаад хөрөнгө оруулагч нарт мөн зориулж, синхрон орчуулгыг англи хэл дээр зэрэг явуулав.

1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ИРЦ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу, ХЭЭХ-д энгийн олонх оролцсоноор буюу Компанийн нийт энгийн хувьцааны 50%+1 хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсоноор хурал хүчин төгөлдөр болохыг тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга, Кэй И Партнерс ХХН-ийн Партнер Б.Ананд, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн R-2025-18 дугаар тогтоолоор банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарласныг дурдаад, ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд ашиглаж буй ХасMeeting аппликейшнд хөндлөнгийн аудитыг Си И Ти Эй ХХК хийсэн ба ITAF, GTAG, ISA315, ISA330 олон улсын стандарт, зааварчилгааг хангасан, хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц болон санал хураалтын үр дүнг хандах эрх болон нууцлалын зөв зохицуулалттайгаар үнэн зөв, бүрэн бүтэн тооцоолдог болохыг баталгаажуулсан гэж тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга Банкны зарласан нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүртгэлийн өдөр болох 04 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар Банкны хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийн хүрээнд халаасалсан 682,057 (зургаан зуун наян хоёр мянга тавин долоо) ширхэг энгийн хувьцааг Компанийн тухай хуулийн дагуу Тооллогын комисс саналын эрхгүй болохыг тогтоосон болохыг зарлав. Ийнхүү шийдвэрлэх асуудал тус бүрээрх саналын эрхтэй нийт хувьцааны тоо 1,052,017,943 (нэг тэрбум тавин хоёр сая арван долоон мянга есөн зуун дөчин гурав) ширхэг энгийн хувьцаа бөгөөд тус хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ХЭЭХ-д 1,009,991,808 (нэг тэрбум есөн сая есөн зуун ерэн нэгэн мянга найман зуун найм) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлын ирц 96.01%-иар бүрдсэнийг зарлав.

Ийнхүү, Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг мэдэгдэв.

ХЭЭХ-д дараах бусад оролцогчид оролцов:

ТУЗ-ийн гишүүд		
1	Санжай Гүпта	ХасБанкны ТУЗ-ийн дарга
2	Г.Цэвэгжав	ХасБанкны Гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн гишүүн (“Гүйцэтгэх захирал”)
3	Б.Уламбаяр	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
4	Нираж Вэдва	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
5	Эми Чой	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
6	Стьюарт Холл	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн



7	Майкл Мадден	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
8	Анджей Витак	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
9	Сюзанна Карр	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
10	Н.Цэлмүүн	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
Гүйцэтгэх удирдлага		
1	Г.Эрдэнэбаяр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал
2	Э.Уламбаяр	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал
3	Б.Еркин	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал
4	С. Дауренбек	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнес хөгжил хариуцсан захирал
5	Д.Мөнхзул	Лизинг хариуцсан захирал
6	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал
7	Г.Зул	Үйл ажиллагаа хариуцсан захирал
8	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал
9	Н.Мөнхцэлмэг	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Хууль хариуцсан захирал (“ХХЗ/ТУЗНБД”)
Тооллогын комисс		
1	Б.Ананд	Кэй И Партнерс ХХН-ийн Партнер
2	Т.Отгон	Кэй И Партнерс ХХН-ийн Хуульч
3	Г.Хажидмаа	Кэй И Партнерс ХХН-ийн Эрх зүйч

ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүд болох Б.Уламбаяр, Нираж Вэдва, Эми Чой болон Стюарт Холл нар нь Хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар биечлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцов.

2. ХУРЛЫН НЭЭЛТ

Банкны Дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дарга Санжай Гүпта (“Хурлын дарга”) ХЭЭХ-ыг даргалав.

Хурлын дарга ХасБанк ХК-ийн ХЭЭХ-д оролцож буй нийт хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд нээлтийн үг хэлэв:

“Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Та бүхнийг ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойших хоёр дахь удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирж оролцож байгаад би туйлын баяртай байна.

2024 онд бид тав дахь жилдээ дараалан түүхэн дээд амжилтаа бататган 171.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Энэ нь өмнөх оноос 20.9 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд ХасБанк нээлттэй хувьцаат компани болж IPO хийхдээ танилцуулж байсан Үнэт цаасны танилцуулгад тусгасан санхүүгийн төсөөллөөс өмнөх оны мөн адилаар бүтэн нэг жилийн өмнө түрүүлж хүрсэн үр дүн юм.

Амжилттай, ашигтай ажиллаж буй байгууллага л нийгэм болоод хувьцаа эзэмшигчдэдээ бодитой хувь нэмэр оруулж чаддаг. 2024 онд бид улс, нийслэл, орон нутгийн төсөвт нийт 120 орчим тэрбум төгрөгийг шууд болон шууд бус хэлбэрээр татвар, шимтгэл, хураамжид төлж хөрөнгө оруулсан.

Манай Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт 19.2% байгаа нь системийн нөлөө бүхий банкуудаас тэргүүлэх үзүүлэлт юм. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт өндөр байгаагаас үл хамааран өөрийн хөрөнгийн өгөөж 25.7% байгаа нь мөн бахдам үзүүлэлт юм. Чанаргүй зээлийн харьцаа



2.0% буюу салбартаа хамгийн бага үзүүлэлт болж байна. Орлого зарлагын харьцаа ойролцоогоор 39% байна.

Та бүхний мэдэж байгаачлан, ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн аль нь ч эцсийн өмчлөгчийн түвшинд банкны 20 хувиас илүүг эзэмшдэггүй болно. Бидний энэхүү хувь эзэмшлийн бүтцээс шууд улбаалаад Банк аливаа нэг эсхүл хоёр этгээдийн эзэмшил, хяналтад оршдоггүй онцлогтой. Энэ нь манай засаглалыг улам сайжруулж буй гэдэгт би итгэдэг.

ХасБанкны бас нэгэн онцлог нь бид холбогдох хууль батлагдахаас ч аль урьд аливаа эцсийн өмчлөгч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны эзэмшлийн хувь хэмжээ 20%-иас хэтрэхгүй байх шаардлагыг банкныхаа дүрэмд тусган мөрдөж байсанд оршино.

Бидний холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа үзүүлэлт Монгол улсад хамгийн бага түвшинд буюу ердөө 2.7%-тай байна. Манай хувьцаа эзэмшигчдийн нэг болох дэлхийд нэр хүндтэй олон улсын арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл тус харьцаа үзүүлэлтэд ордог бөгөөд энэхүү харилцах дансыг гадаад төлбөр тооцоо хийх, худалдааны санхүүжилт олгох зэрэгт ашигладаг. Энэхүү харилцах дансны үлдэгдэл дүнг хассанаар тооцвол, жилийн эцсийн байдлаарх холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа үзүүлэлт ердөө 0.4%-тай байна.

Энэхүү холбогдох этгээдэд олгосон зээлийн хувь хэмжээ бага явдал нь ХасБанкны хамгийн том давуу талуудын нэг бөгөөд жижиг хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудад хамгийн найдвартай хамгаалалт болж өгдөг. ХасБанкны хувь эзэмшлийн бүтэц мөн үүнд шууд нөлөөтэй гэж би хувьдаа боддог.

Өнгөрсөн жил та бүхэн Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт тусгасан шаардлагыг хангах үүднээс Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (ТСН)-ийг ХасБанкинд нэгтгэхээр шийдвэрлэсэн. ХасБанк болон ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нэгтгэх шийдвэрийг гаргасны дараагаар бид Монголбанкнаас нэгтгэх талаарх холбогдох зөвшөөрлийг хүссэн. Гэвч Монголбанкны зүгээс ТСН-ийн нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн бүтцэд өөрчлөлт оруулахыг хүссэн бөгөөд түүний дагуу холбогдох хувьцаа эзэмшигч нь хөрөнгө оруулалтын бүтэцдээ зохих өөрчлөлтийг оруулсан. Монголбанкны зүгээс үүнд татгалзах зүйлгүй талаар мөн албан хариуг ирүүлсэн болно. Энэхүү хувь эзэмшлийн бүтцийн өөрчлөлтөөс үүдээд хуульчид Нэгтгэх гэрээнд хэлбэрийн жижиг нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн бөгөөд үүнд өдгөө хувьцаа эзэмшигч та бүхний зөвшөөрөл шаардлагатай болно.

Та бүхэн зөвшөөрөл өгсний дараагаар бид нэгтгэлийн асуудлаар Монголбанкны зөвшөөрлийг авахаар эрмэлзэж байна. Үргэлжлүүлээд бид хууль тогтоомжийн дагуу шаардлагатай өөр бусад зөвшөөрлийг авч, энэ ондоо багтаан нэгтгэх үйл ажиллагааг эцэслэхээр зорьж буй болно. Нэгтгэлийн үр дүнд ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болж, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангах юм. Та бүхэн мэдэж байгаачлан, ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн дунд Монголын Алт ХХК (МАК)-иас гадна Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC), Япон улсын Орикс корпораци (ORIX), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD), Канадын Үндэсний Банк зэрэг дэлхийн шилдэг байгууллагууд багтдаг.

Ойрын ирээдүйд зөвхөн манай улсад төдийгүй дэлхийн өмнө тулгарах хамгийн том сорилт бол худалдааны дайнаас үүдэх тодорхойгүй байдал юм. Олон улсын худалдааны дэг журам сорилтод орж, дэлхий даяар эдийн засгуудад эрсдэл нүүрлэж байна. Дэлхийн хоёр дахь том эдийн засагтай, манай гол худалдааны түнш болох БНХАУ Ковидын дараах хүндрэлийг худалдааны дайн эхлэхээс өмнө амжилттай давж сэргэж байсан билээ. Мэдээж БНХАУ-ын эдийн засаг энэхүү шуургыг даваад гарах хэдий ч худалдааны дайны хор уршиг богино хугацаандаа илэрч болзошгүй. Энэ бүхэн манай бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж



болзошгүй тул бид ойрын хугацаанд маш хянамгай, соргог байх шаардлагатай тулгарч байна.

Эцэст нь, Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд чадварлаг манлайлал үзүүлж ажилладагт нь гүн талархал илэрхийлье. Мөн гүйцэтгэх удирдлагын баг болоод нийт ажилтнууддаа тууштай хөдөлмөр, зүтгэлийнх нь төлөө талархал илэрхийлмээр байна.

Түүнчлэн, энэхүү завшааныг ашиглаад манай ТУЗ-ийн гишүүд болон хувьцаа эзэмшигчид та бүхэндээ үзүүлж ирсэн дэмжлэг, туслалцаа болон удирдлагад чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Баярлалаа.”

3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хулын дарга Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавыг хурлын дэгийг танилцуулахаар индэрт урив. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав ХасБанкны ХЭЭХ-д хүрэлцэн ирсэн хүн бүрийг халуун дотноор угтан авч талархлаа илэрхийлээд, хувьцаа эзэмшигчдэд ХЭЭХ-ын дэгийг танилцуулав.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Гүйцэтгэх захирал ХЭЭХ-ын хэлэлцэх асуудлыг ТУЗ-өөс баталж, нийт хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу урьдчилан мэдээлсэн гэдгийг дурдав.

Хурлын хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар танилцуулав:

Танилцуулах асуудал:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.

Шийдвэрлэх асуудал:

1. ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай;
2. ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай;
3. ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
4. ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:
 - Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон өөрчлөн байгуулах;
 - Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусгах;
5. Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
6. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай.

Танилцуулгын дараагаар, хурлын дэг болон хэлэлцэх асуудалд холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуух асуулт буй эсэх талаар Гүйцэтгэх захирал тодруулав. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй болно.

5. ХАСБАНКНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

- Үйл ажиллагааны онцлох үйл явдал

Гүйцэтгэх захирал Банк тайлант хугацаанд БЖДБ эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжих зорилгоор 236 сая ам.долларын эх үүсвэр татан төвлөрүүлэх гэрээ байгуулсан болохыг тэмдэглэв. Ингэснээр 2025 он болон түүнээс хойших жилүүдийн зээлийн өсөлтийг дэмжих эх үүсвэрийг бүрдүүлэх чухал гэрээ, хэлцлүүдийг 2024 онд



эцэслэсэн байна. Мөн Банкны Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн хөтөлбөр Даян дэлхийн уур амьсгалын түншлэлийн сан (GCPF)-гийн 2024 оны шилдэг төслөөр шалгарсан талаар үйл ажиллагааны онцлох үйл явдлуудыг танилцуулав.

Тэрээр Moody's болон Fitch Ratings агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахын сацуу ХасБанкны зээлжих зэрэглэлийг мөн “B2/тогтвортой” болон “B+ тогтвортой” болгон тус тус нэг шат ахиулан сайжруулсан талаар дурдав. Үүний үр дүнд гадаад эх үүсвэрийн зардал буурах ач холбогдолтой болно.

Цаашлаад ТУЗ-ийн шийдвэр болон зохицуулагч байгууллагуудаас олгосон зөвшөөрлийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны өгөөжийг сайжруулах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн талаар тэмдэглэв. Энэ асуудалд холбогдох мэдээллүүд ХасБанк болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршсан болохыг мэдээлэв.

Мөн Зорилготой хадгаламж, Асуудалгүй үйлчилгээ, Амар зээл, урт хугацааны Уртаар зээл, Слайс (Slice) зээл, ПОС-н орлого барьцаалсан дижитал зээл, БЖДБ эрхлэгчдийг дэмжих зорилгоор Ханбогд хөгжлийн хурдасгуур Оюу толгой сангийн түншлэл, Засгийн газрын гол хөтөлбөрүүдийг дэмжих зээлийн хөтөлбөр, байгууллагын банкинд зориулсан аппликейшнийг нийтэд шат дараатайгаар зах зээлд нэвтрүүлж буй талаар болон Тэмүүлэл карт, Хасын Хүлэгүүд карт, Олимп карт зэрэг шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн талаар танилцуулав.

- **Санхүүгийн үзүүлэлт**

Гүйцэтгэх захирал 2024 оны санхүүгийн гол үзүүлэлтүүдийг онцлон танилцуулав. Үүнээс, цэвэр ашиг 171.7 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны 142.1 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас даруй 20.9%-ийн өсөлттэйгээр Үнэт цаасны танилцуулгад тусгасан 141.9 тэрбум төгрөгийн зорилтыг давуулан биелүүлсэн байна. Мөн балансын бүтэц болон ашигт ажиллагаа сайжирч, Банкны нийт актив 6.32 их наяд төгрөгийг давж оны эхнээс 23.5%-иар өссөн амжилттай ажилласан байна.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн санхүүгийн өөр бусад үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн өгөөж (ROE), зээл, санхүүгийн түрээсийн багц, харилцах, хадгаламж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний тоон үзүүлэлтүүдийн талаар танилцуулав. Тэрээр Банкны гол стратегийн хүрээнд санхүүгийн нийт үзүүлэлтүүдийн тогтвортой өсөлтийг жил тутам хадгалахыг зорьдог талаар тайлбарлав.

Тэрээр Банкны нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 34.5% өссөнтэй зэрэгцээд активын чанараа сайн хэвээр хадгалан ажилласны үр дүнд нийт багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурч 2.0%-д хүрсэн болохыг онцлон тэмдэглэв.

Банкны зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк (ойролцоогоор нийт зээлийн багцын 70%-ийг эзэлдэг), Байгууллагын банк болон Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг бөгөөд тэдгээрийн зээлийн багцын өсөлтийн талаар товч танилцуулав.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн харилцах, хадгаламж (дотоод эх үүсвэр), гадаад эх үүсвэр, зээлжих зэрэглэл зэргийн талаарх голлох үзүүлэлтүүдийг онцлон Банкны санхүүгийн үзүүлэлтүүд тогтвортой байгааг тэмдэглэв.



Мөн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр буюу оны сүүлчийн арилжааны өдөр Банкны хувьцааны хаалтын ханш 826.0 төгрөгт хүрч, өмнөх оны хаалтын ханш болох 629 төгрөгөөс 31.3%-иар өссөн амжилттай үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлт нь мөн ХасБанк IPO хийх үед санал болгож байсан 677 төгрөгөөс 22%-иар өссөн үзүүлэлт болно. Ийнхүү нэгж хувьцаанд ногдох ашиг 163 төгрөг 10 мөнгө байна.

ХасБанкны нэгэн онцлог нь жилд 2 удаа ногдол ашиг тараах бодлогыг тогтмол хэрэгжүүлдэг бөгөөд энэ хүрээнд 2024 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 18.0 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр тараан ажилласан. Түүнчлэн, 2024 оны жилийн эцсийн буюу II хагас жилийн хуримтлагдсан ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг энэ хурлаар хэлэлцэн шийдвэрлэх болно.

- **Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт**

Гүйцэтгэх захирал Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хүрээнд дараах гурван үзүүлэлтийг тоймлон хүргэв:

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт: Монголбанкнаас банкуудад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 9%-иар тогтоосон байдаг. Мөн системийн нөлөө бүхий банкуудад нөөц интервалын шаардлага 3-4% хүртэл нэмж тогтоодог. ХасБанк нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтээ 2024 оны тайлант хугацаанд 19.2% буюу байвал зохих хэмжээнээс 6.7 нэгж хувиар давуулан хангаж ажилласан. Ийнхүү тус үзүүлэлтийг давуулан хангаж буй нь ХасБанкны аливаа болзошгүй эрсдэлийг хүлээх чадвар тэр хэмжээгээр ахиу болох, ирээдүйн зээлийн өсөлтийг хангах болон ногдол ашиг хуваарилах боломжтой буюу үйл ажиллагаагаа цааш тогтвортой эрхлэн удирдах чадвартай болохыг илтгэж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт: Монголбанкнаас арилжааны банкуудад төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийн доод хэмжээг 25%-иар тогтоосон байдаг. ХасБанк нь өөрийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд түргэн борлогдох актив хөрөнгийг бэлэн мөнгө эсхүл хамгийн бага эрсдэлтэйд тооцогдох хэрэгсэлд байршуулан удирдаж байгаа бөгөөд 2024 оны байдлаар тус харьцаа үзүүлэлтийг 38.4%-д хадгалан ажилласан.

Бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд: Гүйцэтгэх захирал Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг Банк хангаж ажилласныг онцлов.

- **Банкны засаглалын тайлан**

Гүйцэтгэх захирал цааш нь засаглалын тайланг танилцуулж, түүний хүрээнд 2024 оны ХЭЭХ-аар хууль тогтоомжийн дагуу сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг танилцуулав. Мөн ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тайлант хугацаанд хуралдсан хуралдаан болоод ТУЗ-өөс гаргасан шийдвэр, баталсан дотоод засаглалын бодлого, журмуудын талаар товч танилцуулав.

- **Сангаас хаасан зээлийн тайлан**

Гүйцэтгэх захирал 2024 оны 11 дүгээр сарын ТУЗ-ийн хурлаар сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэсэн талаар хувьцаа эзэмшигчдэд тайлбарлаж, тухайн сангаас хаасан зээлүүд нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан



тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагыг бүрэн хангасан болохыг тэмдэглэв. Мөн Банк нь зээлийг сангаас хаасан эсэхээс үл хамаарч өр төлүүлэх ажиллагааг хэвийн үргэлжлүүлж ажиллаж байна.

Тэрээр сангаас хаасан зээлийг бүтээгдэхүүнээр ангилан танилцуулж, БЖДБ-ийн, орон сууцны, хэрэглээний, тээврийн хэрэгслийн зээлийн бүтээгдэхүүнд нийт 1,761 сая төгрөгийн үнийн дүн бүхий 183 зээлийг сангаас хаасан болохыг тэмдэглэв.

ХасБанкны ТУЗ нь Банкны 2024 оны үйл ажиллагааны тайланг сайтар хянан үзсэний үндсэнд, тус тайлан нь ХасБанкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор ил тод илэрхийлсэн гэж 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-09 дүгээр тогтоолоороо дүгнэсэн болохыг тэмдэглэв.

Гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлахыг хувьцаа эзэмшигчдээс хүсэв.

Танилцуулгын дараагаар Гүйцэтгэх захирлын сануулснаар, хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй тул, хуралд цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан асуусан дараах асуулт/саналыг Гүйцэтгэх захирал танилцуулав:

1. Хувьцааны талаарх мэдээлэл дутмаг байгаа буюу брокер, дилерийн компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдэд өгөх мэдээлэл дутмаг байгаа;
2. Өөрийн эзэмшиж буй хувьцаа нь үр хүүхдэд өвлөгдөх эсэх болон хувьцааны мэдээллийг цахим хаягаар тогтмол ирүүлэх боломжтой эсэх, хувьцаа эзэмшигчдэд санхүүгийн мэдлэг, мэдээлэл олгох эсэх.
3. Хувьцааны мэдээллийг илүү үр өгөөжтэй болгох.

Гүйцэтгэх захирал дээрх асуултад дараах байдлаар хариулав:

1. Банкны зүгээс өөрийн үйл ажиллагаа болон хувьцааны талаарх мэдээлэл олгох ажлын хүрээнд брокер, дилерийн компаниудтай хамтрах хамтын ажиллагааг цаашдаа улам сайжруулахад анхаарч ажиллах болно. Харин Банкны хувьцаанд холбогдох гол мэдээллийг бид гагцхүү өөрийн цахим хуудас бус, хууль тогтоомжийн дагуу Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудаст тухай бүр байршуулан ажилладаг болно. Иймд хувьцаа эзэмшигчид маань мөн холбогдох мэдээлэлтэй тус цахим хуудсаар дамжуулан тухай бүр танилцах бүрэн боломжтой.
2. Хувьцаа эзэмшигч таны эзэмшиж буй хувьцаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуулийн өв залгамжлалд холбогдох зохицуулалтын дагуу өвлөгдөх бүрэн боломжтой. Хувьцааны талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн цахим хаягт тогтмол хүргүүлэх асуудлын хувьд зохистой шийдэл, боломжийг судлах болно. Өмнө дурдсанчлан, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудаст хувьцааны талаарх мэдээллийг тогтмол оруулаад зогсохгүй, Банкны өөрийн цахим хуудаст мөн улирал тутмын санхүү, үйл ажиллагааны тайланг ил тодоор нийтэлдэг. Түүнчлэн, ХасБанкны албан ёсны сошиал хуудсаар тус тайлангийн талаар мэдээлэл бүхий онлайн танилцуулгыг хийдэг.



3. ХасБанкны цахим хуудаст 'Хөрөнгө оруулагчид' хэмээх тухайлсан булан байдаг. Холбогдох үндсэн гол мэдээллүүдийг тухайн цэст тусгасан байдаг. Мөн Банкны цахим хуудсыг улам сайжруулах үүднээс шинэчлэх ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл болоод түүний хүртээмжийг улам сайжруулахад анхаарч ажиллах болно.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигч тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан дараах асуултыг нэмж асуув:

- 2024 оны санхүү, үйл ажиллагааны тайлантай танилцахад төлөвлөгөөний дагуу ажилласан байна. ХасБанкны 2025 оны бизнес төлөвлөгөө буюу энэ онд хэдэн тэрбум төгрөгийн орлого, ашигтай ажиллах талаар танилцуулахыг хүсье.

Гүйцэтгэх захирал тус асуултад дараах байдлаар хариулав:

- Банкны зээлийн багцыг 2025 ондоо 20 орчим хувиар өсгөх төлөвлөгөөтэй байна. Бид IPO хийх үед танилцуулж байсан Үнэт цаасны танилцуулгад жил тутам 20 орчим хувийн зээлийн тэлэлт хийх буюу өөрийн хөрөнгийн хэмжээг тэр хэрээр нэмэгдүүлэхээр тусгасны дагуу ийнхүү төлөвлөсөн бөгөөд үүнийг харгалзан 2025 оны төсвийг баталсан. Ингэснээр татварын дараах цэвэр ашиг 10 орчим хувиар өсөхөөр төлөвлөсөн. Энэ нь мэдээж Хурлын даргын дурдсанчлан, Монгол Улсын эдийн засаг дахь худалдааны дайны нөлөөллөөс шалтгаалан тодорхой хэмжээнд өөрчлөгдөх боломжтой.

6. ХАСБАНКНЫ 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Хурлын дарга Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаярыг Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулахаар индэрт урив. Мөн тэрээр Эрснт энд Янг Монголия Аудит ХХК-ийн ахлах партнер болон бусад мэргэжилтнүүд хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар энэхүү хуралд хүрэлцэн ирснийг онцлов.

Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргээд дараах танилцуулгыг хийв:

Банкны тухай хуулийн дагуу ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдэдээ болон олон нийтэд хуулийн хугацаандаа багтааж 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр бүрэн эхээр нь нээлттэй толилуулсан байгаа.

2024 онд дэлхийн 4 том аудитор байгууллагын нэг болох Эрснт энд Янг Монголия Аудит ХХК нь хуулийн дагуу ХасБанкны хараат бус аудитороор сонгогдон ажилласан бөгөөд ХасБанкны санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандарт, дүрэм журмын дагуу хяналт хийж, удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь НББОУС болон СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн.

Аудитлагдсан тайлангийн 4-8 дахь хуудаст буй хараат бус аудиторын дүгнэлттэй хувьцаа эзэмшигчид та бүхэн танилцах боломжтой. Мөн аудитлагдсан тайлан нь санхүүгийн үндсэн дөрвөн тайлангаас гадна нэмэлт 34 тодруулгатай, нийт 93 хуудас тайлан бөгөөд монгол болон англи хэлээр үйлдэж нийтэлсэн болно. Тэрээр аудитлагдсан санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийн талаар товч танилцуулав.

Компанийн тухай хуулийн дагуу ХасБанкны Аудитлагдсан тайланг ТУЗ хэлэлцэж **“ХасБанкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан байна”** гэж дүгнэсэн болохыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ТУЗ-



ХАСБАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
ийн R-2025-17 дугаар тогтоолоор баталгаажуулсан бөгөөд дүгнэлтийг Хувьцаа
эзэмшигчдийн хуралд ийнхүү танилцуулж байна гэв.

Санхүү хариуцсан захирал Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2024
оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталж
шийдвэрлэхийг хувьцаа эзэмшигчдээс хүсэв.

Мөн тэрээр ТУЗ-ийн дүгнэлт болон аудитлагдсан санхүүгийн тайланд холбогдох хувьцаа
эзэмшигчдийн асуултад хариулахад бэлэн буй талаар мэдэгдэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн
асуудалд оров.

7. ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАЙЛАН

Хурлын дарга ХасБанкны ТУЗ-ийн нийт хараат бус гишүүдийг төлөөлж тайланг
танилцуулах ТУЗ-ийн хараат бус гишүүн Нираж Вэдваг индэрт урив.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Нираж Вэдва ХЭЭХ-д оролцож буй хувьцаа
эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс
тайланг англи хэлээр танилцуулсныг орчуулагчийн тусламжтайгаар Монгол хэл дээр
дараах байдлаар шууд хөрвүүлэв:

“Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,

Миний бие ТУЗ-ийн нийт хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс 2024 оны санхүүгийн
жилийн тайланг танилцуулахдаа таатай байна.

Бидний зүгээс ТУЗ-ийн стратегийн алсын хараа, засаглалын манлайлал, тогтвортой
хөгжлийн төлөөх хүчин чармайлтад чин сэтгэлээсээ талархаж буйгаа юун түрүүнд
илэрхийлье. Мөн банкны стратегийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд сэтгэл зүрхээ зориулан
ажилласан Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын баг хамт олон болон ажилтнууддаа
талархал илэрхийлж байна. Тэдний хүчин чармайлтаар ХасБанк дахин нэг жил ийнхүү
өндөр амжилтыг үзүүлээд байна.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

ХасБанкны 2024 онд үзүүлсэн өндөр амжилт нь санхүүгийн гол үзүүлэлтүүдэд дараах
байдлаар тусгалаа олсон.

- Татварын дараах цэвэр ашиг: 171.7 тэрбум төгрөг (өмнөх оноос 20.9%-иар өссөн)
- Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ: 2% (тогтмол бууруулан ажиллаж байна)
- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа: 19.2%
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа: 38.4%
- Нийт зээлийн багц өмнөх оноос 34.5%-иар өссөн.
- Харилцах, хадгаламжийн хэмжээ 19.1%-иар өссөн.
- Зээлжих зэрэглэл: Moody's болон Fitch олон улсын байгууллагаас үнэлгээг нэг шатлалаар ахиулж, тогтвортой төлвийг хэвээр хадгалсан.

Түүнчлэн ХасБанк нь 2020 оноос хойш тогтмол, сайн өсөлтийг үзүүлж буй нь жилийн
дундаж өсөлтийн нийлмэл хувь (ЖДӨНХ)-д мөн тусгалаа олсон. Энэ сүүлийн 4 жилийн
хугацаанд ХасБанкинд эерэг өөрчлөлтийг бий болгоход хувь нэмрээ оруулагч алсын
хараа, төлөвлөгөөг тодорхойлсон ТУЗ-ийн дарга болоод банкныг удирдлагаар хангаж
ажилласан ТУЗ-ийн нийт гишүүддээ мөн талархлаа илэрхийлэх нь зүйтэй.

- Үйл ажиллагааны ашиг - ЖДӨНХ 30.3%.



- Татварын дараах цэвэр ашиг: 2020 онд цэвэр ашиг 33.7 тэрбум төгрөг байснаас 2024 онд 171.7 тэрбум төгрөг болж өссөн (ЖДӨНХ: 50.2%).
- Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 2020 онд 12.2% байснаас 2024 онд 25.7% болж өссөн.
- Нийт хөрөнгө - ЖДӨНХ 17.2%.

Стратегийн санаачилга ба Дижитал шилжилт

ХасБанк өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний багцийг сайжруулж, харилцагчдын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах зорилгоор шинийг санаачилж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсээр байна. Үүнд:

- Асуудалгүй, Зорилготой хадгаламж, Амар зээл, Slice зээл зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн.
- Тэмүүлэл, Хасын Хүлэгүүд, Олимп, Ирээдүй болон түншлэгч байгууллагуудын карт болох картын шинэ бүтээгдэхүүн танилцуулсан.

Эдгээр санаачилгуудын тусламжтайгаар ХасБанкны харилцах, зээлийн болон хадгаламжийн харилцагчдын бааз ихээхэн өргөжсөн билээ.

Мөн банк нь дижитал шилжилтэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж, харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үүднээс хэрэглэхэд хялбар дижитал интерфэйс, санхүүгийн бүтээгдэхүүнд саадгүй хандах боломж, мэдээлэл шууд боловсруулах технологийг нэвтрүүлсэн. Цаашлаад, маркетинг идэвхжүүлэлт, брэнд таниулах хүчин чармайлтууд, Фейсбүүк, Инстаграм зэрэг нийтийн сүлжээний платформуудыг хөшүүрэг болгон ашиглах, салбарын арга хэмжээнүүдэд оролцох зэрэг үйл ажиллагаануудыг хийж ХасБанкны зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлээд байна.

Засаглал болон ТУЗ-ийн үйл ажиллагаа

ТУЗ нь компанийн засаглалын хүрээнд, 2024 оны турш идэвхтэй оролцоотойгоор дараах хуралдаануудыг зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргасан болно:

- ТУЗ-ийн 7 хурал хуралдуулсан.
- 16 цахим санал хураалт явуулсан.
- 53 тогтоол баталсан.

Засаглалын асуудлаар хийж гүйцэтгэсэн гол ажлуудаас дурдвал:

- Бие даасан, тогтсон процессын дагуу, эрсдэлийг хамгийн бага түвшинд барих үүднээс холбогдох этгээдтэй хэлцэл хийх ажиллагаанд хатуу хяналт тавьж ажилласан.
- Хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэгч байгууллага болохын хувьд Санхүүгийн Зохицуулах Хорооноос банкны засаглалыг 93.1% буюу сайн гэж үнэлсэн нь 2023 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.
- Хөрвөх чадваргүй хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохицуулагч байгууллагын зөвшөөрлийн үндсэнд Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг ил тодоор батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалж ажилласан.
- ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүдийг ТУЗ-ийн аливаа хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах ажиллагаанд тэгш оролцох бололцоог хангаж, засаглалын сайн тогтолцоог бэхжүүлэн ажилласан.
- Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Төгсгөлийн үг



ХасБанк нь хүний нөөцийн эргэцийн харьцааг бага түвшинд хадгалж, өндөр бүтээмжийг хөхиүлэн дэмжих байдлаар ажлын эерэг, бүтээлч орчныг цогцлоон ажиллаж байна. Богино, дунд, урт хугацааны тодорхой стратеги, чадварлаг удирдлагын баг, ажилтнуудтай болохын хувьд ХасБанк нь төлөвлөсөн зорилтоо биелүүлж, өсөлтийн хурдаа тогтвортой хадгалах бүрэн бололцоотой хэвээр болно.

Бидэнд итгэлээ хүлээлгэн, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн нийт оролцогч талууддаа талархал илэрхийлье.

Баярлалаа.”

Тайланг танилцуулсны дараагаар Хурлын даргын зарласнаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

8. ХАСБАНКНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Хурлын дарга Банкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах талаар танилцуулахаар Гүйцэтгэх захирлыг дахин индэрт урив.

ХасБанк өмнө нь 2024 оны I хагас жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилсан. Энэ удаа ТУЗ нь Компанийн тухай хуулийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн R-2025-03 дугаар тогтоолоороо Банкны 2024 оны жилийн эцсийн буюу II хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ зарлан хуваарилахаар санал болгосон талаар Гүйцэтгэх захирал тэмдэглэв. Тэрээр Банкны Дүрэмд заасны дагуу энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж буйг тайлбарлав. Тус ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашигт нэгж хувьцаанд 27 төгрөг буюу нийт 28.42 тэрбум төгрөгийг зарлан хуваарилахыг дэмжсэн байна.

Ингэснээр Банкны 2024 оны цэвэр ашгаас нийт 47.4 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж буй буюу Үнэт цаасны танилцуулгад тусгасан 2024 онд 42.6 тэрбум төгрөгийг ногдол ашигт тараах төсөөллийг давуулан биелүүллээ.

Мөн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байхаар санал болгосон байна.

Түүнчлэн Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомжид нийцүүлэн Монголбанкны 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн албан тоотоор ХасБанкнаас ногдол ашиг хуваарилахад татгалзах зүйлгүй талаар албан хариу хүлээн авсан болохыг дурдав. Хэрэв хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд СЗХ-ны зохицуулалтын дагуу 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д шилжүүлэх ба Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК нь хувьцаа эзэмшигчдийн нэрийн дансанд байршуулахыг онцлов.

Танилцуулгын дараагаар Гүйцэтгэх захирлын сануулснаар, хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ХЭЭХ-д цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчийн тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан асуусан дараах асуултыг Гүйцэтгэх захирал танилцуулав:

- Ногдол ашгийг цаашид банкны харилцах дансаар авах боломжтой эсэх.

Гүйцэтгэх захирал дээрх асуултад дараах байдлаар хариулав:



- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хувьцаат компани нь ногдол ашгийг гагцхүү эрх бүхий зуучлагч байгууллага болох Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн нэрийн дансанд байршуулах үүрэгтэй. Харин Банкны нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмших нөлөө бүхий хувьцаа эзэмшигч ногдол ашгийг өөрийн арилжааны банк дахь харилцах дансанд шилжүүлж авах хүсэлтийг бичгээр ирүүлсэн тохиолдолд л тийнхүү шилжүүлэх боломжтой талаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон болно.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан дараах асуултыг нэмж асуув:

1. Банк 2024 онд нийт 171.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан талаар танилцууллаа. Түүнээс 28.4 тэрбум төгрөгийг ногдол ашигт хуваарилна гэж ойлголоо. Үлдсэн 150 гаруй тэрбум төгрөгийг юунд зарцуулах талаар цэвэр ашгийн зарцуулалтын хуваарилалтыг танилцуулна уу. Жишээлбэл тодорхой хувийг хувьцаагаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрт зарцуулах эсэх. Мөн нэгж хувьцаанд 27 төгрөг хуваарилах болсон үндэслэл болоод цаашдын бизнес төлөвлөгөөг танилцуулна уу.
2. Хаан банктai харьцуулахад нэгж хувьцаанд хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ бага байна. Ногдол ашгаас өгөөж хүртэх ашиг сонирхолтой жижиг хувьцаа эзэмшигчид бидэнд энэ талаар тайлбарлаж өгнө үү. Мөн ХасБанкны хадгаламжийн хүү бусад банктai харьцуулахад бага байгаа нь иргэдийн хадгаламжийг татан төвлөрүүлэх шаардлагагүй гэж үзэж байгаатай холбоотой юу?

Гүйцэтгэх захирал дээрх асуултуудад дараах байдлаар хариулав:

1. Цаашдын хувьцаа эзэмшигчдийн хурлаар ногдол ашгийн танилцуулгад таны хэлсэн саналыг тусгая. ХасБанкны хувьд 2024 оны 171.7 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас нийтдээ 47.4 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилж буйг онцольё. Таны хэлсэн 28.4 тэрбум төгрөгийн дүн нь гагцхүү 2024 оны II хагас жилийн цэвэр ашгаас хуваарилахаар санал болгосон дүн бөгөөд үүн дээр 2024 оны I хагас жилийн цэвэр ашгаас хуваарилсан 19 тэрбум төгрөгийг нэмснээр ногдол ашигт хуваарилсан нийт үнийн дүн гарна. Үлдсэн 124 орчим тэрбум төгрөгийн зарцуулалтын хувьд бид 2025 оны зээлийн өсөлтөд зориулж төлөвлөсөн. Манай банкны бизнесийн гол стратеги нь ашигт суурилсан, эрсдэлээ сайн удирдсан өсөлтийг хангах юм. Өөрөөр хэлбэл, зах зээлд өөрийн эзлэх хувийг тэлэхээс илүүтэйгээр ашигт ажиллагаандаа төвлөрч байна. ХасБанк БЖДБ эрхлэгчдийг дэмжих стратегийн хүрээнд гол өсөлтийг Иргэдийн банкны сегментэд хийхээр төлөвлөсөн. Түүнчлэн, хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийн хүрээнд ТУЗ-өөс батлагдсан нийт үнийн дүнгийн 15 орчим хувь л өнөө хүртэл биелэгдэж ирсэн. Иймд хуримтлагдсан ашгаас хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрт маш бага дүнг зориулах буюу дийлэнх хувийг бизнесээ өргөжүүлэх болон зээлийн багцын өсөлтөд зарцуулах болно.
2. Юун түрүүнд нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ нь тухайн байгууллага нийт хэдэн ширхэг хувьцаа гаргасантай шууд холбоотой байдаг учир ийнхүү үнийн дүнг шууд харьцуулахад учир дутагдалтай. Харин хувьцааны өгөөж талаас харьцуулбал илүү бодитой, үр дүнтэй харьцуулалт болно. Үүнд 2 гол хүчин зүйлийг харгалзан үзнэ: i) хувьцааны ханшийн өсөлтийн өгөөж болон ii) ногдол ашгийн өгөөж болно. Нэмээд ногдол ашиг тараах дамтамж ойр байх тохиолдолд ногдол ашгийн өгөөжийг хурдан хүртэх боломжтой болдог. ХасБанк IPO хийх үеэр хөрөнгө оруулсан хувьцаа эзэмшигчдийн хувьд 2025 оны эхний улирлын байдлаар ногдол



ашгийн өгөөж 12.6%-тай, хувьцааны үнэ 25.6%-ийн өсөлттэй буюу хувьцааны өгөөжийг 38.2%-д хүргэж ажилласан байна. ХасБанкны стратегийн хүрээнд ирээдүйн өсөлтийг тогтвортой үзүүлэх үүднээс өөрийн хөрөнгийг өндөр түвшинд хадгалан үлдээх байдлаар ногдол ашгийг зохих түвшинд барих бодлогыг гүйцэтгэх удирдлагын баг болон ТУЗ хэрэгжүүлдэг. Түүнчлэн, системийн банкуудтай харьцуулахад ХасБанкны хугацаат хадгаламжийн хүү бага байж ирсэн, өдгөө мөн арай бага байгаа боловч бусад арилжааны банкууд мөн өөрсдийн хүүгээ шат дараатайгаар бууруулж, ХасБанкны санал болгож буй хүүтэй ойролцоо түвшинд ирснийг онцлох нь зүйтэй. ХасБанк нь өөрийн өсөлтөд таарсан хадгаламжийн эх үүсвэрийг татаж, актив пассивыг удирддаг бөгөөд хадгаламжийн хүүний дайнд оролцдоггүй онцлогтой. Тус хүүний дайнд оролцож, санал болгох хүүгийн хэмжээг нэмэхэд банкны системийн хүү тэр чигтээ өсөх эрсдэлтэй байдаг тул бидний зүгээс зохистой санхүүгийн удирдлагын хүрээнд ойролцоогоор эх үүсвэрийн 2/3 хувийг хадгаламж эзэмшигчдээс татаж, үлдсэн 1/3 хувийг гадаад эх үүсвэрээр бүрдүүлдэг. Үүнтэй холбогдуулан бид хадгаламжийн хүүг улирал тутам хянаж, зохих шийдвэрийг гарган ажилладаг.

9. ХАСБАНКНЫ ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

А. ЗНДЦУХ-г Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон хуваах

Хурлын дарга ХХЗ/ТУЗНБД Н.Мөнхцэлмэгийг ХасБанкны Дүрэмд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийг танилцуулна уу хэмээн индэрт урив.

ХХЗ/ТУЗНБД Н.Мөнхцэлмэг ХасБанкны ХЭЭХ-д оролцож буй хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (ЗНДЦУХ)-г Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон хуваах асуудалд холбогдуулан ХасБанкны Дүрэмд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулав.

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн.

Тиймээс одоогийн ЗНДЦУХ-г а) ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, залгамж халааг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэр дэвшүүлэх хороо болон б) компанийн засаглалын бодлого журам, ТУЗ-ийн бүтэц, цалин хөлсний бодлого, урамшууллын бүтцийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг тусгаж Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар ХасБанкны ТУЗ 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-08 тоот тогтоолоор мөн санал болгосон.

Иймээс СЗХ-ны зөвлөмжийн дагуу дараах байдлаар Банкны Дүрмийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар Хувьцаа эзэмшигчдэд санал болгов:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль,	8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын <u>Нэр дэвшүүлэх хорооноос</u> тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны



Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын <u>хорооны</u> Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын <u>хорооны</u> гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх , <u>Нэр дэвшүүлэх</u> болон <u>Засаглал</u> , цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

В. Ахмадын сангийн зохицуулалтыг нэмж тусгах

ХХЗ/ТУЗНБД үргэлжлүүлэн Ахмадын сангийн зохицуулалтыг нэмж тусгах байдлаар ХасБанкны Дүрэмд оруулахаар санал болгож буй нэмэлтийн талаар танилцуулав.

Банк нь Ахмад настны тухай хууль (2017)-ийн дагуу Банкнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд дэмжлэг, тусламж үзүүлэх зорилгоор байгуулсан Ахмадын сантай. Энэ асуудлын хүрээнд Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр компаниудад өөрийн дүрэмдээ Ахмадын сан байгуулах болон түүнд компанийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувь (3%)-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх асуудлыг тус тус тусгайлан тусгахыг үүрэг болгосон.

Иймээс ХасБанкны Дүрмийг хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэх, тус Дүрэмд Ахмадын сангийн зохицуулалтыг тусгах талаар ХасБанкны ТУЗ 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-11 тоот тогтоолоор зөвлөмж хүргүүлсний дагуу ХасБанкны Дүрэмд дараах агуулга бүхий 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг нэмэхээр Хувьцаа эзэмшигчдэд санал болгов:

Нэмэх заалт



5.5. Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

Ийнхүү хурлын дэгийн дагуу, ХХЗ/ТУЗНБД-ын зарласнаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

10. НЭГТГЭХ ГЭРЭЭ БОЛОН НЭГТГЭХ НӨХЦӨЛ, ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Хурлын даргын урьснаар, Гүйцэтгэх захирал ХасБанк болон түүний толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (ТСН)-ийн хооронд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээ, холбогдох Нэгтгэх нөхцөл, журамд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулав.

Тэрээр Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт зааснаар системийн банк бүр “аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа нь тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх” нөхцөлийг биелүүлэх ёстой. Банкууд энэ шаардлагыг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө хангасан байх үүрэгтэй талаар товч тайлбарлав.

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлыг хэлэлцээд ХасБанкны толгой компани болох ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх нь зүйтэй гэж 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр шийдвэрлэсэн. Ингэснээр ТСН-ийн 10 хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болж, Банкны тухай хуулийн шаардлагыг хангах юм.

Монголбанкнаас нэгтгэх өөрчлөн байгуулалтын хүсэлтийг хянах явцад ТСН-ийн нийт гаргасан хувьцааны 20.39%-ийг өөрийн охин компани (МАК Инвест Кэй Эф Ти)-иар дамжуулан эзэмшдэг “Монголын Алт” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон. Уг өөрчлөлтийг Банкны тухай хуульд нийцүүлэх шаардлагатай болсон тул ТСН дэх тэдний хөрөнгө оруулалтын бүтцийг өөрчилж, нэг эцсийн өмчлөгчийг ТСН дэх эцсийн өмчлөгчийн бүтцээс хасах өөрчлөн байгуулалт хийгдээд байна.

Энэхүү өөрчлөлтийн дагуу ТСН-ийн 20.39%-ийг МАК Инвест Кэй Эф Ти-ийн оронд МАК Инвест Эс Жи эзэмших болсон.

Ийнхүү ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан, ХасБанк болон ТСН хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд тус өөрчлөлтийг тусгах шаардлагатай болсон тул, Нэгтгэх гэрээ болон түүнд холбогдуулан баталсан Нэгтгэх нөхцөл, журамд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар ХасБанкны ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-10 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж буй болно.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн нэмэлт, өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй материалууд буюу хөндлөнгийн хуулийн фирм Батбаяр энд Партнэрс ХХН-өөс гаргасан хуулийн дүгнэлтийн хураангуй, ТСН болон ХасБанкны хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмж хүргүүлэх тухай ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-10 тоот тогтоол, ТСН болон ХасБанкны хооронд байгуулах Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ (“Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”)-ний төсөл, Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журамд оруулах нэмэлт, өөрчлөлт зэргийг хувьцаа эзэмшигчдэд урьдчилан тараасан болохыг онцлов.



Танилцуулгын дараагаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв. Гүйцэтгэх захирал Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээнд хуулийн дүгнэлт гаргасан хөндлөнгийн зөвлөх компани мөн хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар хүрэлцэн ирсэн болохыг дурдав.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэлэлцэх дараагийн асуудалд оров.

11. ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД ХасБанкны Дүрмийн 8.6(v) дахь заалтад зааснаар ТУЗ-ийн төсөв тогтоох нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэрлэх асуудал тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр ХасБанкны ТУЗ-өөс 2025 оны төсвийг 7 тэрбум 250 сая төгрөгийн дүнтэйгээр оруулсан болохыг тайлбарлав.

ТУЗ-ийн төсөв 2024 онд 6,7 тэрбум төгрөгөөр батлагдаж байсан бөгөөд бодит гүйцэтгэл мөн түүнтэй ойролцоо дүнтэй байсан болохыг тэмдэглэв.

Тэрээр цаашлаад ТУЗ-ийн 2025 оны төсөвт (i) хөлс, нэмэгдэл, урамшуулал (гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүнээр ажилласныхаа төлөө аливаа, хөлс, нэмэгдэл, урамшуулал авдаггүй), (ii) бусад зардал (татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зорчих болон буудаллах зардал, хурал зохион байгуулах зардал, ТУЗ-д үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээний төлбөр зэрэг) багтдаг болохыг дурдав.

Танилцуулгын дараагаар ХХЗ/ТУЗНБД-ын сануулснаар, хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигч тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдуулан дараах асуултыг асуув:

- Юун түрүүнд өнгөрсөн онд амжилттай, өндөр ашигтай, сайн ажиллаж компанийн үйл ажиллагааг чадварлагаар удирдан зохион байгуулсан Г.Цэвэгжав захирал, удирдлагын баг хамт олонд талархал илэрхийлье. Мөн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэнд ТУЗ-ийн баг хамт олонд мөн талархал илэрхийлье. Компанийн засаглалын кодекст зааснаар ТУЗ-ийн цалин, урамшууллын зардал болон хурал зохион байгуулах бусад зардал нь тусдаа байх шаардлагыг тавьдаг. Иймд тус шаардлагад нийцүүлэн ТУЗ-ийн төсвийн нийт дүнгийн хэчнээн хувь нь ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал болоод бусад зардалд хуваарилж буй талаар задаргаа, өмнөх оноос хэрхэн өссөн талаар танилцуулна уу.

ХХЗ/ТУЗНБД тус асуултад дараах байдлаар хариулав:

- Өмнөх онтой харьцуулж харуулах хүсэлтийг хүлээн авлаа. Цаашид анхаарах болно. Банкны зүгээс ТУЗ-ийн төсвийг i) хөлс болон ii) бусад зардал гэж хоёр ангилан, тус тусын нийт дүнг тогтоолын төслийн хавсралтад ил тод тусгасан. Хөлсний тухайд, тус мэдээлэл нь хувь хүний хөрөнгийн мэдээлэл буюу хувийн мэдээлэлд хамаарах тул, тухайн этгээдийн зөвшөөрөлгүйгээр гишүүн тус бүрээр задлан нийтэд мэдээлэх боломжгүй. Иймд бид i) хөлс болон ii) бусад зардлыг нийт дүнгээр нь ангилан харуулсан бөгөөд энэ нь Санхүүгийн Зохицуулах Хорооны Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа гэж үзэж байна.

ХЭЭХ-д биечлэн оролцож буй өөр нэгэн хувьцаа эзэмшигч ТУЗ болон ТУЗ-ийн хараат бус гишүүдэд хандан тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдолгүй дараах асуултыг асуув:



- ХЭЭХ-аар өнгөрсөн оны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг танилцууллаа. Гэхдээ хамгийн гол асуудал нь ирээдүйд хувьцаа эзэмшигч би хөрөнгө оруулалтаа хэвээр хадгалах эсхүл хувьцаагаа зарах шийдвэр гаргалтад туслах Банкны 2025 оны төлөвлөгөөний талаар танилцуулсангүй. Энэ хүрээнд ямар бодлого баримталдаг болоод Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх асуудлаар Банк ямар урт хугацааны болон дунд хугацааны стратеги баримталж буй талаар жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болохын хувьд ТУЗ-ийн хараат бус гишүүдээс асууя. Зарим нэгэн банк нээлттэй хувьцаат компани байхаа больж, хаалттай хувьцаат болсонтой холбогдуулаад энэ хүрээнд ХасБанкны баримтлах бодлого юу вэ? Мөн тийнхүү ирэх оны төлөвлөгөө болон дунд, урт хугацааны стратегийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж байхыг хүсье.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Уламбаяр тус асуултад дараах байдлаар хариулав:

- Юун түрүүнд Банкны ирэх жилийн төлөвлөгөө, үйл ажиллагааны зорилт, стратегийг ТУЗ-ийн түвшинд өмнөх оны сүүлчээр хууль тогтоомжийн дагуу маш дэлгэрэнгүй хэлэлцэн баталдаг. Тус төлөвлөгөө, зорилтыг ямар агуулгын хүрээнд хувьцаа эзэмшигчдэд танилцуулах талаарх асуудалд ТУЗ хяналт тавьдаггүй. Энэ асуудлыг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж зэрэг эрх бүхий байгууллагуудын зохицуулалт, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн манай гүйцэтгэх удирдлагын баг хариуцан ажилладаг. Түүнчлэн, Банкны ТУЗ-ийн нийт хараат бус гишүүд хууль тогтоомж, Банкны бодлогын дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлөх, хамгаалах ажлыг хичээнгүйлэн гүйцэтгэж байгаа болохыг баталж хэлье. Бидний авч буй мэдээлэл, гаргаж буй шийдвэрийн талаар бүхэлд нь хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх нь зохимжгүй болно. Бид хууль тогтоомжийн дагуу байгууллага дотооддоо өөрсдийн үйл ажиллагааг тайлагнахаас гадна улирал тутам Монголбанкинд өөрсдийн ажлыг тайлагнадаг. Түүн дотор ТУЗ-ийн хараат бус гишүүн болохын хувьд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мөн тусгаж, тайлагнадаг. Зөвхөн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр зогсохгүй, Банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баг бүхэлдээ хууль тогтоомж, Банкны стратегийн дагуу гагцхүү жижиг хувьцаа эзэмшигчид гэлтгүй нийт хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалахын төлөө ажиллаж буй болохыг онцлон тэмдэглэе.

Дээрх асуудалд холбогдуулан, Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав нь ТУЗ-ийн гишүүн болохын хувьд дараах тайлбарыг нэмж хэлэв:

- Банкны тухай хуулийн дагуу системийн нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, өөр бусад банк нь хаалттай хувьцаат компанийн хэлбэртэй байх шаардлагатай билээ. Энэ хуулийн шаардлагыг биелүүлэх үүднээс нэр дурдсан банк нь нээлттэй хувьцаат компаниас хаалттай хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн гэж ойлгож байгаа. ХасБанк нь системд нөлөө бүхий банк болохын хувьд хуулийн дагуу нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх бөгөөд хаалттай хувьцаат компани эсхүл ХХК болох байдлаар хэлбэрээ өөрчлөх төлөвлөгөөгүй, боломжгүй болно. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхээр авч буй арга хэмжээний тухайд, манай банк нь хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, тэдэнтэй харилцах тухайлсан нэгжүүд бий. Бид улирал тутам тайланг нийтэд мэдээлж, брокерийн уулзалт буюу хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид чөлөөтэй асуулт асуун, хариулт авах боломж бүхий шууд уулзалтыг цахимаар нээлттэй зохион байгуулдаг. Түүнчлэн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар асуудлыг өөрийн бодлого журам, төлөвлөгөөндөө тусган, түүнийг зохион байгуулан ажиллаж байна. Танаас ирүүлсэн нэгэн чухал саналыг үүгээр хүлээн авч, цааш цаашдын хурлаар Банкны ирээдүйн төлөвлөгөө, стратегийн талаар өндөр ач холбогдолтой цөөн хэдэн мэдээллийг хувьцаа эзэмшигчдэдээ танилцуулж ажиллах болно. ХасБанкинд итгэж хөрөнгө оруулсан 10 мянга гаруй



жигжиг хувьцаа эзэмшигчдэдээ талархлаа илэрхийлье. ХасБанктайгаа хамт урт хугацаанд хувьцаа эзэмшигч байгаасай гэж бидний зүгээс хүсч байна. Баярлалаа.

Дээрх асуултад холбогдуулан Хурлын дарга мөн тайлбар өгөв:

“Асуулт тавьсанд баярлалаа. Хамт олныхоо хэлсэн дээр миний зүгээс мөн нэмж дараах зүйлсийг хэлэхийг хүслээ.

Юуны өмнө миний бие аль ч бусад томоохон хувьцаа эзэмшигчтэй ямарваа нэгэн холбоо хамааралгүй болно. Хувьцаа эзэмшигчид ийнхүү өөрсөддөө холбоо хамааралгүй хүнээр ТУЗ-ийг удирдуулж буй нь зорилготой, учир шалтгаантай. Миний бие ч мөн та бүхний нэгэн адил жигжиг хувьцаа эзэмшигч гэдгийг дуулахад та бүхэнд таатай байх гэж найдна.

ХасБанкны ТУЗ-ийн удирдлагын арга барил нь Монгол Улсын бусад компаниудын ТУЗ-өөс арай ялгаатай гэж би бодож байна. Удирдлагын зарчим нь- зөвхөн нэр төдий бус, үйл хэрэг дээр- ТУЗ-ийн хуралд хувьцаа эзэмшигч бус зөвхөн ТУЗ-ийн гишүүн л гэж бий. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигч хийгээд ТУЗ-ийн гишүүний давхар дээлтэй хэн ч байсан ТУЗ-ийн хуралд оролцохдоо зөвхөн ТУЗ-ийн гишүүний дан дээлээ өмсч, хувьцаа эзэмшигчийн дээлээ гээдэг. Үндсэн зарчим бол бүх ТУЗ-ийн гишүүд бүх хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн төлөө ажиллах ёстой. Түүнчлэн манай ТУЗ-ийн 1/3 нь хараат бус гишүүд. Хараат бус эсэхийг Монголбанкны нарийн шалгуурын дагуу тогтоодог. Түрүүн дурдсанчлан миний бие аливаа нэг хувьцаа эзэмшигчтэй холбоо хамааралгүй хэдий ч Монголбанкны зүгээс намайг хараат бус гишүүн гэж үзэхгүй. Яагаад гэвэл би ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн ТУЗ-ийн даргын албан тушаалыг давхар хашдаг учраас шаардлага хангахгүй.

Жигжиг хувьцаа эзэмшигчдийн эрхийн тухайд - нэг их дэлгэрэнгүй орохгүйгээр би ганцхан тодорхой жишээ дурдъя. Биднийг IPO буюу анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгохоос ч өмнө Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцааны хөрвөх чадвар, түргэн мөнгөжих боломж сул болох нь бидэнд тодорхой байсан. Бид биржийн байдал хэрхэн сайжрахыг ажиглах зорилгоор нэг жил хүлээсэн. Таван системийн банк хувьцаагаа нийтэд санал болгоход нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхийг хүлээсэн. Энэ нэг жилийн хугацаанд бид жигжиг хувьцаа эзэмшигчид гэнэтийн нөхцөл байдлын улмаас хувьцаагаа түргэн арилжаалах шаардлагатай үед тун чиг зовлонтой тулдаг болохыг ажигласан. Бид хууль тогтоомжийн хүрээнд жигжиг хувьцаа эзэмшигчдэдээ туслах гарц гаргалгааг олохоор маш нээлттэйгээр ярилцсан. Монголын Хөрөнгийн Бирж дээрх аливаа хувьцааны хөрвөх чадвар сайжрахад хугацаа орохын хажуугаар жигжиг хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зарахад хэцүү хэвээр байна. Энэ нөхцөл байдал болон хууль, компанийн дүрэмд үндэслэн бид хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг боловсруулсан. Уг хөтөлбөрийн цорын ганц зорилго нь хувьцааны мөнгөжих чадварыг зах зээлд нэмэгдүүлж банкны жигжиг хувьцаа эзэмшигчдэд туслах явдал юм. Хөтөлбөрийг ТУЗ болон Монголбанк баталж олон нийтэд маш ил тод, нээлттэй зарласан. Хувьцаа эзэмшигчдийн бүх асуудлыг биш юм аа гэхэд нэлээдгүй асуудлыг шийдэж чадсан гэж би бодож байна.

Нэмэлт тайлбар шаардлагатай бол надтай холбогдож болно. Асуулт хариултын дараа, цайны завсарлага болоход би хурлын танхимын гадна байж байх бөгөөд надтай ярилцах боломжтой.

Хувьцаа эзэмшигчдийн өгөөжийн хувьд бүх хувьцаа эзэмшигчид ижил өгөөжийг хүртдэг. Мөн хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг ногдол ашиг, хувьцааны үнийн өсөлтийн хослол гэж үзэх ёстой. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав та бүхэнд хувьцааны үнийн өсөлт, ногдол ашгийн үр дүнд IPO гаргаснаас хойш 19, 20 сарын хугацаанд хувьцаа эзэмшигчид ямар өгөөж хүртсэн талаарх тооцооллыг



танилцуулсан. Бид маш хатуу, чанд Үнэт цаасны хууль тогтоожид захирагддаг тул илүү дэлгэрэнгүй хэлэх боломжгүй юм. Гэхдээ миний хэлж чадах зүйл бол бид бусад банкны хувьцааны ханшийг ажигладаг, мөн манай хувьцаа тэдгээр банкны хувьцаатай харьцуулахад хэрхэж байгааг ч би ажиглаж, хянаж байдаг.

Бидний стратеги болон бидний гаргаж буй нийт шийдвэрүүд урт хугацааны өсөлт дэвшил, хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны өгөөжид үндэслэж гардаг. Мөн би яриагаа манай гараг дээрх хамгийн шилдэг хөрөнгө оруулагчдаас иш татаж өндөрлүүлмээр байна. Тэдгээр хөрөнгө оруулагчид дийлэнхдээ “сайн стратегитай, сайн засаглалтай, сайн менежменттэй, өсч хөгжих боломжтой, бизнес болоод хувьцаа эзэмшигчдийн өгөөжийн хувьд алсын хараатай компанид хөрөнгө оруул” гэж хэлдэг билээ.

Бид энд байгаа цагт, би энд байгаа цагт бид Банкныг ийм байдлаар удирдаж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ТУЗ-д нэн чухалчлах болно гэдгийг би та бүхэнд үүгээр амлаж байна.

Баярлалаа.”

12. САНАЛ ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Үүний дараа, Хурлын дарга шийдвэрлэх 7 асуудлуудаар санал хураалтыг эхлүүлэв. Тэрээр дэлгэц дээр эхлүүлсэн 10 минутын хугацаа тоолж дуусмагц бүх санал хураалт нэгэн зэрэг дуусгавар болохыг сануулаад хувьцаа эзэмшигчдийг санал хураалтдаа оролцохыг уриалж тэдгээрийн саналын үнэ цэнтэй болохыг тэмдэглэв.

Саналын хураалтын цаг дуусч санал хураалт хаагдсаны дараа хурлын дэгийн дагуу завсарлага авч, Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх ажлыг эхлүүлэв.

13. САНАЛ ХУРААЛТЫН ҮР ДҮН: ШИЙДВЭР

Хурлын даргын урьснаар, Тооллогын комиссын дарга Б.Ананд хувьцаа эзэмшигчдээр батлуулахаар санал болгосон асуудал тус бүрийн санал хураалтын үр дүнг танилцуулав.

Санал хураалт #1: ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,990,058	99.92%
Татгалзсан		
Түдгэлзсэн		

Шийдвэр #1:

ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.92 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.



Санал хураалт #2: ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,990,048	99.92%
Татгалзсан		
Түдгэлзсэн	1,010	0,00%

Шийдвэр #2:

ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.92 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #3: ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай

ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,991,058	99.92%
Татгалзсан		
Түдгэлзсэн		

Шийдвэр #3:

ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.92 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #4.а: ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: ЗНДЦУХ-г хуваах

ХасБанкны Дүрэмд ЗНДЦУХ-г Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулахтай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны Дүрэмд (ЗНДЦУХ-г Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулахтай холбогдуулан) нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:



	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,990,911	99.92%
Татгалзсан		
Түдгэлзсэн	147	0.00%

Шийдвэр #4.a:

ХасБанкны Дүрэмд (ЗНДЦУХ-г Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулахтай холбогдуулан) нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.92 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #4.b: ХасБанкны Дүрэмд нэмэлт оруулах тухай: Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусгах

ХасБанкны Дүрэмд Ахмадын сангийн зохицуулалтыг нэмж тусгах байдлаар нэмэлт оруулах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны Дүрэмд (Ахмадын сангийн зохицуулалтыг нэмж тусгах байдлаар) нэмэлт оруулах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,882,914	99.91%
Татгалзсан	53,178	0.01%
Түдгэлзсэн	50,456	0.00%

Шийдвэр #4.b:

ХасБанкны Дүрэмд (Ахмадын сангийн зохицуулалтыг нэмж тусгах байдлаар) нэмэлт оруулах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.91 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #5: ТСН болон ХасБанкны хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ТСН болон ХасБанк хороонд байгуулсан Нэгтгэх гэрээ (болон түүнд холбогдуулан баталсан Нэгтгэх нөхцөл, журам)-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ТСН болон ХасБанк хороонд байгуулсан Нэгтгэх гэрээ (болон түүнд холбогдуулан баталсан Нэгтгэх нөхцөл, журам)-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,888,236	99.91%
Татгалзсан	400	0.00%
Түдгэлзсэн	102,422	0.01%

Шийдвэр #5:



ТСН болон ХасБанкны хооронд байгуулсан Нэгтгэх гэрээ (болон түүнд холбогдуулан баталсан Нэгтгэх нөхцөл, журам)-нд нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.91 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #6: ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай

ХасБанкны ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,925,538	99.92%
Татгалзсан	50,000	0.00%
Түдгэлзсэн	14,770	0.00%

Шийдвэр #6:

ХасБанкны ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.92 хувийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга ХЭЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлээд хурлыг албан ёсоор хаав.

Гарын үсэг зурсан:

Санжай Гүпта

Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын дарга

Гарын үсэг зурсан:

Н.Мөнхцэлмэг

Хууль хариуцсан захирал бөгөөд
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
03 дугаар сарын 17-ны өдрийн Р-2025-18 дугаар тогтоолын Хавсралт 5



САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
2.	ХасБанкны 2024 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
3.	ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах	☐	☐	☐
4.a	ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах: - Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон өөрчлөн байгуулах	☐	☐	☐
4.b	ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах: - Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусгах	☐	☐	☐
5	Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	☐	☐	☐
6.	ТУЗ-ийн 2025 оны төсөв	☐	☐	☐

Хувьцаа эзэмшигчдийн хуралд тавих асуулт болон санал*



*Цаг хугацааны бололцоог харгалзан, хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн зарим асуулт, саналыг ээлжит хурлын үеэр танилцуулж, хариулт өгч болно. Ийнхүү хэлэлцэх нь урьдчилан ирүүлсэн саналд гагцхүү хамаарахыг анхаарна уу. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид нь хурлын үеэр асуултаа шууд тавих боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2025 оны ... сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
2. Та саналаа урьдчилан олоогийн хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот болон орон нутаг дахь ХасБанкны салбар, тооцооны төвүүдээр дамжуулан цаасан хэлбэрээр, эсхүл цахим хэлбэрээр өгөх боломжтой.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____

